

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТАНИЛЦУУЛГА

Сангийн орлого



Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн орлогыг нийт 1,450.8 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн. Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд 2021 оноос нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжиж улсын төсвөөс эрүүл мэндийн даатгалын санд тусламж, үйлчилгээний санхүүжилтийг шилжүүлж байна. Үүний дагуу эрүүл мэндийн даатгалын сангийн орлогод улсын төсвийн шилжүүлэг, эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлого аж, ахуйн нэгж байгууллага, төсөвт байгууллага болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлогыг тус тус тусгав.

Сангийн зарлага



Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийг 2020 оноос эхлүүлж эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанар, үр дүн, гүйцэтгэлийн дагуу санхүүжүүлж байна.

Шинэчлэлийн хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт, анхан шатны эрүүл мэндийн байгууллагын нэг иргэний тарифаар тооцох зардлыг тусгав. Бүх шатны эмнэлгийн иргэнд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үр дүн, гүйцэтгэлээр олгох санхүүжилтэд нийт 1,358.4 тэрбум төгрөг төсөвлөв.

Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, 15.1.4, 15.1.5, 15.1.7, 15.1.9, 15.1.11, 15.1.13-д тус тус заасан эрүүл мэндийн байгууллагын эмчийн бичсэн жороор хөнгөлөлттэй олгох эмийн нэр төрөл, жагсаалтын дагуу олгох эмийн үнийн хөнгөлөлтийн зардалд 67.3 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн эрсдэлийн сангийн хөрөнгийг 40.0 тэрбум төгрөг байхаар тус тус тооцов.

Эрүүл мэндийн даатгалын сангийн авлага

Эрүүл мэндийн даатгалын сангийн Капитал банкнаас авах авлагыг барагдуулахаар тооцож тусгав.